



## ШҮҮХ БОДИТ ҮНЭНД НИЙЦСЭН ШИЙДВЭР ГАРГАХЫН ТУЛД ХЭРГИЙН ТАЛААР ИДЭВХТЭЙ ТОДРУУЛГА (ACTIVE CLARIFICATION) ХИЙХ НЬ АЧ ХОЛБОГДОЛТОЙ

(Япон улсын дээд шүүхийн шийдвэрийн хураангуй<sup>1</sup>)

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** 1970 年(才)52

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 1970 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

**Шийдвэрийн төлөв:** Хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосон.

### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

А компани нь Д хөдөө аж ахуйн хоршоодын холбоонд (цаашид “Д холбоо” гэх) хүнсний бүтээгдэхүүн савлах зориулалттай модон хайрцаг (цаашид “модон хайрцаг” гэх) нийлүүлдэг байсан. Гэвч А компанийн нөхцөл байдлаас шалтгаалан нийлүүлэлт хүндрэлтэй болсон тул Б компанид хандан тус компанийн оронд Д холбоонд модон хайрцаг нийлүүлэхийг хүссэн. *Б компани Д холбоонд бараа нийлүүлэх тохиолдолд өөрийн компанийн нэрээр бус А компанийн нэрээр нийлүүлэх, А компани Б компанид нийлүүлсэн барааны үнийг төлөх, мөн А компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга баталгаа гаргахаар тохиролцсон байна.* Ингээд Б компани нь 1966 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 1970 оны 06 дугаар сарын 17-ны өдөр хүртэл 820.000 иений үнэ бүхий модон хайрцгийг Д холбоонд нийлүүлж, А компаниас 400.000 иенийг хүлээн авсан. Иймд үлдэгдэл төлбөрийг Д холбооноос гаргуулахаар, А компани болон компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт (цаашид “хариуцагч нар” гэх) холбогдуулан баталгааны үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар тус бүр нэхэмжлэл гаргажээ.

### ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүх:** Д холбоо А компанид өгсөн захиалгын дагуу нэхэмжлэгч нь А компанийн туслан гүйцэтгэгчийн хувиар модон хайрцаг нийлүүлсэн тул Б компани болон Д холбоо хоёрын хооронд худалдах-худалдан авах гэрээний харилцаа үүсээгүй. Иймд Д холбооноос шаардах нэхэмжлэлийн хэсгийг хэрэгсэхгүй болгосон. *Хариуцагч нарт гаргасан шаардлагын тухайд А компанийн нэрээр Д холбооноос хариу төлбөр авахыг батлан даасан бөгөөд Б компани нь үүнийг шаардаж байгаа хэмээн тайлбарлажээ.* Иймд хариуцагч нарт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.
- 2. Давж заалдах шатны шүүх:** Хариуцагч нар анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч, давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан. Давж

<sup>1</sup> 最高裁昭和 45 年 6 月 11 日 第一小法廷判決

[https://www.courts.go.jp/app/files/hanrei\\_jp/134/055134\\_hanrei.pdf](https://www.courts.go.jp/app/files/hanrei_jp/134/055134_hanrei.pdf)



заалдах шатны 2 дахь шүүх хуралдаанд Б компани буюу нэхэмжлэгч тал “Энэхүү арилжаанд А компанийн нэрээр нийлүүлсэн бус, манай компанид төлөх хариу төлбөрийг А компани хариуцаж, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга баталгаа гаргасан” хэмээн тайлбар гаргажээ. Давж заалдах шатны шүүх дээрх тайлбарыг харгалзан үзсэний дагуу хариуцагчийн гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

3. **Хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол:** Давж заалдах шатны 2 дахь шүүх хуралдаанд шүүх тодруулга хийснээр, нэхэмжлэгч модон хайрцгийн төлбөрийг А компани хариуцаж, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга баталгаа гаргасан гэж тайлбараа өөрчилсөн. *Энэхүү тодруулга нь туйлын шударга бус бөгөөд шүүхийн тодруулах эрхийн хэмжээнээс хэтэрсэн тул магадлалыг хүчингүй болгож өгнө үү гэж гомдол гаргажээ.*
4. **Хяналтын шатны шүүх:** Хяналтын шатны шүүх тодруулга хийх эрхийг дараах байдлаар тайлбарласан байна. *“Шүүхийн тодруулга (釈明の制度) нь мэтгэлцэх зарчим хэлбэрийн төдий явагдсаны улмаас үүссэн алдааг засах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой болгох, хэргийн нөхцөл байдлыг үнэн зөвөөр тогтоох замаар бодит үнэнд нийцсэн шийдвэр гаргах зорилгоор хуульчлагдсан. Тухайлбал, тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц болон тогтоогдсон баримтаас үзэхэд, өөр хуулийн зохицуулалтад үндэслэн нэхэмжлэгч хэргийн үйл баримтын талаар тайлбар гаргавал нэхэмжлэлийн шаардлагыг хангах боломжтой бөгөөд талуудын хооронд үүссэн маргааныг үндсээр нь шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ. Гэсэн хэдий ч нэхэмжлэгч ийм тайлбар гаргаагүй нь түүний төөрөгдөл эсвэл анхааралгүй байдлаас шалтгаалсан байвал, уг тодруулга нь өөр нэхэмжлэлийн үндэслэлд хамаарч байлаа ч шүүх өөрийн бүрэн эрхийн хүрээнд тухайн нөхцөлийг нэхэмжлэгчээс тодруулах боломжтой гэж үзэх нь зүйтэй. Түүнчлэн зарим тохиолдолд хуулийн зохицуулалтын тодорхой агуулгыг дурдах байдлаар зохигч нарын бодит санааг тодруулах нь тохиромжтой байж болох юм.”*
- Энэ хэргийн тухайд, нэхэмжлэгч талын анхны шаардлага нь нэхэмжлэгч болон Д холбооны хооронд байгуулсан модон хайрцаг худалдах-худалдан авах гэрээний төлбөрийн үүргийг хариуцагч нар баталгаа гаргагчийн хувиар гүйцэтгэх талаар байсан. Харин нэхэмжлэгч талын давж заалдах шатны 2 дахь шүүх хуралдаанд гаргасан тайлбараас үзэхэд, түүний шаардлага нь ажил гүйцэтгэх гэрээний дагуу А компаниас ажлын хөлс шаардаж, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас баталгааны үүргийн гүйцэтгэлийг шаардах байдлаар өөрчлөгдсөн. *Хариуцагч нар давж заалдах шатны шүүх хуралдааны үеэр “баталгаа гаргасан үйл баримт байхгүй” гэсэн тайлбар хурлын тэмдэглэлд байгаа бөгөөд энэ нь баталгааны талаар идэвхтэй үгүйсгэж байсан болохыг илтгэж байна. Тиймээс давж заалдах шатны шүүх хуралдаанд нэхэмжлэгчийн гаргасан тайлбар нь шүүхийн тодруулгын дагуу хийгдсэн гэж үзсэн ч, энэ нь шүүхийн тодруулгын зохистой*



*хэмжээнээс хэтрээгүй байна.* Иймд хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

---o0o---